

Итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдол: БНСУ-тай харьцуулах нь

Баярболдын АРИУНТЭС*

-
- I. Оршил
 - II. Итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдолтой холбоотой зохицуулалтын онол, практик
 - III. Харьцуулсан судалгаа
 - IV. Дүгнэлт
-



* Хуульч, Өмгөөлөгч, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрант.



Итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдол: БНСУ-тай харьцуулах нь

Баярболдын АРИУНТЭС Хуульч, Өмгөөлөгч, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрант.

Хураангуй: Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрөө тухайн үйлдлийг биечлэн хийхийг хүсэхгүй, амжихгүй, эсхүл чадахгүй байх тохиолдолд төлөөлөгчөөр дамжуулан оролцох тохиолдол байдаг. Гэтэл төлөөлөх бүрэн эрхгүй этгээд шударгаар төлөөлөн гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн тохиолдолд төлөөлөх бүрэн эрхгүй гэдэг үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бусд тооцох нь гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалж чадахгүйгээс гадна түүнд хохиролтой нөхцөл байдлыг үүсгэдэг. Цаашид итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдолтой холбоотой шинээр гарч болзошгүй маргааныг урьдчилан харж, түүнд таарсан эрх зүйн зохицуулалтыг онолын хувьд хэрхэн тайлбарлаж, ойлгох тухай өөрийн саналаа хүргэхэд энэхүү судалгааны ажлын ач холбогдол оршино. Ингэхдээ Монгол Улсын иргэний хуулиар тус харилцаа нь шүүхийн практик дээр хэрхэн хэрэглэгдэж, оновчтой зохицуулагдаж байгааг судална. Түүнчлэн төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлээс үүдэн гарах гуравдагч этгээдийг хамгаалах зохицуулалтуудын хэрэгжилт, итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлын онолын тайлбар, хуульд хэрхэн тусгагдсан талаар судлах, тодорхой санал дэвшүүлэхийг зорьсон бөгөөд судалгааны арга зүйн хувьд гадаад улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсан болно. Энэхүү хүрээнд Герман Францын тогтолцоог судлаад холимог шинэ тогтолцоог бүрэлдүүлсэн улс болох БНСУ-г сонгосон бөгөөд манай улсын Иргэний хуулийн 65.1-ийн агуулга, үг үсэг нь БНСУ-ын зохицуулалттай адил төсөөтэй тул сайн туршлагыг нь өөрийн орны хуульд системчлэх саналаа тусгахаар оролдсон.

Түлхүүр үг

Төлөөлөл, Итгэмжлэл, итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдол, иргэний эрх зүйн оролцогч, гуравдагч этгээд

I. ОРШИЛ

Дэлхий дахинд үйлчилж буй глобалчлал, мэдээлэл технологийн хувьсал, эдийн засгийн харилцаа хурдацтай хөгжихийн хэрээр хүмүүс ч илүү завгүй амьдрал руу хөтлөгдөж байна. Энэ цаг үед хүмүүс өдөр тутамдаа хэлцэл хийх харилцааны нэг тал болон оролцох нь түгээмэл болсон. Ийм нийгэмд хүмүүс цаг хугацаа, эдийн засгаа хэмнэх зорилготойгоор төлөөлөгч оролцуулах нь



дэлгүүрийн худалдагчаас эхлээд албан үйл ажиллагаа эрхэлж байгаа бүхий л хуулийн этгээдэд ч хамааралтай ойлголт юм. Тийнхүү иргэний эрх зүйд төлөөллийн харилцаа чухал байр суурийг эзэлдэг.

Монгол Улсын хувьд энэхүү сэдвийн талаар буюу төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцэл тэр дундаа итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлын хүрээнд нарийвчлан судлагдсан бүтээл, ном товхимол байхгүй байсан. Харин төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлийн онолын тайлбар, иргэний эрх зүйн харилцаанд итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдол зэрэг ерөнхий асуудалтай холбоотой Э.Байгал, "Иргэний эрх зүйн ерөнхий анги"(2009), Б.Буяншиг, "Иргэний эрх зүйн удиртгал" (2014) зэрэг сурах бичгүүдэд агуулгын хувьд гардаг.

Төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлээс үүссэн эрх зүйн маргаан их байдаг талаар дээр дурдсан. Монгол Улсын иргэний хуулиар тус харилцаа нь шүүхийн практик дээр хэрхэн хэрэглэгдэж, оновчтой зохицуулагдаж байгааг судлах зорилготой. Түүнчлэн төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлээс үүдэн гарах гуравдагч этгээдийг хамгаалах зохицуулалтуудын хэрэгжилт, итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлын онолын тайлбар, хуульд хэрхэн тусгагдсан талаар судлах, тодорхой санал дэвшүүлэхийг зорьсон бөгөөд судалгааны арга зүйн хувьд БНСУ-ын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлах болно. Учир нь БНСУ нь Герман Францын тогтолцоог судлаад холимог шинэ тогтолцоог бүрэлдүүлсэн улс юм. Манай улсын Иргэний хуулийн 65.1-ийн агуулга, үг үсэг нь БНСУ-ын зохицуулалттай адил төсөөтэй тул сайн туршлагыг нь өөрийн орны хуульд системчлэх саналаа тусгахаар оролдсон болно. Ингэхдээ мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, иргэний эрх зүйн өмнөх үеийн хууль тогтоомжуудыг судлах аргуудыг тус тус ашиглан энэхүү судалгааны ажлыг бичихийг зорилоо.

Сүүлийн үед орон сууц захиалах гэрээтэй холбоотой маргаан элбэг тохиолдож байна. Компанийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гэрээ байгуулж тэрхүү төлөөлөл нь хүчин төгөлдөр бус болсны улмаас хэлцлийн нөгөө тал болох гуравдагч этгээдийн эрх ашиг зөрчигдөнө гэсэн үг. Мөн цаашид итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдолтой холбоотой шинээр үүсэж болзошгүй маргааныг урьдчилан харж, түүнд таарсан эрх зүйн зохицуулалтыг онолын хувьд хэрхэн тайлбарлаж, ойлгох тухай өөрийн саналаа хүргэхэд энэхүү судалгааны ач холбогдол оршино.

II. ИТГЭМЖЛЭЛ ОЛГОСОН МЭТ ТООЦОХ ТОХИОЛДОЛТОЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ОНОЛ, ПРАКТИК

1. Төлөөлөл, төлөөлөх бүрэн эрхийн тухай үндсэн ойлголт

Бодгаль этгээд¹ өөрийн биеэр эсхүл өөр этгээдээр төлөөлүүлэн гэрээ байгуулна. Иргэний эрх зүйн чадамжгүй болон хязгаарлагдмал чадамжтай этгээд өөрөө хэлцэл хийх боломжгүй тохиолдолд хууль ёсны төлөөлөгчдийнхөө

¹ Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн.



үйлдлээс хамааралтай байдаг. Хуулийн этгээдийн өмнөөс мөнтэдний төлөөлөгчид, гүйцэтгэх захирал болон бусад төлөөлөх бүрэн эрхтэй этгээдүүд аливаа эрх зүйн үр дагавар бүхий үйлдлийг хийнэ.² Хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болох ба төлөөлөгчийн бүрэн эрх хуулийн дагуу буюу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ гэж Иргэний хуулиар зохицуулсан байна.³ Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дэх хэсэгт "Хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болно"⁴ гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл хэн нэгэн этгээд бусдын нэрийн өмнөөс хэлцэл хийхийг төлөөлөл гэж ойлгоно. Энэхүү судалгааны ажлын хүрээнд Иргэний хуулийн 62-70 дугаар зүйлд заасан хэлцэлд төлөөлөхтэй холбоотой асуудлыг хөндөж байгаа тул төлөөлөл гэх ойлголтоос эхлэн судалъя.

Төлөөлөл (*representation agency*) – төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа бөгөөд үүнээс үүсэх эрх, үүрэг бусад үр дагавар нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болно.⁵ Төлөөлөгч (*delegant*) – итгэмжлэлээр төлөөлөхөд төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байж болно. Төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болно. Төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй. Төлөөлүүлэгч нь төлөөлөгч болон түүнтэй хэлцэл хийх гуравдагч этгээдэд төлөөлүүлэх тухайгаа болон төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар амаар буюу бичгээр мэдэгдсэнээр төлөөлөгчид бүрэн эрх олгож болно.⁶ Төлөөлөл гэдэг нь нэг талаар иргэний эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн үйлдэл, нөгөө талаар субъектүүд бие биедээ итгэх итгэл болон эдийн засаг, эрх зүйн туслалцаа үзүүлж буй хэлбэр юм⁷.

Зарим судлаач төлөөллийг "төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс хэлцэл хийх санал гаргах (актив) эсвэл төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс хэлцэл хийх саналыг хүлээн авах, зөвшөөрөх (пассив) байдлаар бусдад иргэний эрх зүйн үр дагавар үүрүүлж буй үйлдэл" гэж тодорхойлдог.⁸ Үүнийг тайлбарлавал хууль болон итгэмжлэлийн агуулгаас хамаарч төлөөлөгч илүү идэвхтэй, өөрийн хүсэл зоригоо бие даан илэрхийлж байвал актив бүрэн эрх, харин гуравдагч этгээдийн саналыг хүлээн авч, зөвшөөрөх эрхтэй бол пассив бүрэн эрхтэй гэж ойлгож болно.

Төлөөллийн харилцаа нь дараах үндсэн 4 шинжийг агуулж байдаг. Үүнд:

- Төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс
- Төлөөлүүлэгчийн эрх ашгийн төлөө

² Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний эрх зүйн удиртгал, хоёрдугаар дэвтэр*, (Улаанбаатар: Соёмбо принтинг, 2014), 234 дэх тал.

³ Түмэнжаргалын Мэндсайхан, *Гэрээний эрх зүй*, (Улаанбаатар: ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, 2021), 127 дахь тал.

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002 он, №07.

⁵ Содномын Должин, *Хувийн эрх зүйн тайлбар толь бичиг*, (Улаанбаатар: 2019) 175 дахь тал.

⁶ Мөн тэнд.

⁷ Тэшигийн Мөнхжаргал, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, (Улаанбаатар: 1997), 88 дахь тал.

⁸ Батаагийн Тэмүүлэн, Дагвадоржийн Энхзул, Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2008), 163 дахь тал.



- Төлөөлүүлэгчийн зардлаар
- Төлөөлүүлэгчид эрх, үүрэг үүсэх

Төлөөллийг хэрэгжүүлэх явцад эрх зүйн 3 төрлийн харилцаа үүсдэг байна. Үүнд:

1. Төлөөлөгч, төлөөлүүлэгч хооронд үүсэх эрх зүйн харилцаа
2. Төлөөлөгч, гуравдагч этгээдийн хооронд үүсэх харилцаа
3. Төлөөлүүлэгч, гуравдагч этгээдийн хооронд үүсэх эрх зүйн харилцаа юм.

Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн олгосон бүрэн эрхийг хүлээн авсан дотоод (төлөөлөгч ба төлөөлүүлэгчийн хоорондын) харилцаа болон тухайн бүрэн эрхийн хүрээнд төлөөллийг хэрэгжүүлж буй гадаад (төлөөлөгч ба гуравдагч этгээд хоорондын) харилцаа юм.⁹ Ийнхүү ангилснаар дотоод харилцааны тухай мэдээгүй эсхүл мэдэх боломжгүй гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах тал дээр зохистой гэж үздэг. Өөрөөр хэлбэл дотоод харилцаатай холбоотой зөрчил нь гадаад харилцаанд нөлөө үзүүлэхгүй байх, гэрээ хүчин төгөлдөр хэвээр үлдэх, улмаар гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах зохицуулалтыг иргэний хуульд тусгах нэн шаардлагатай гэж хэлж болохоор байна. Төлөөлүүлэгчээс төлөөлөгчид мэдэгдэж бүрэн эрх олгохыг дотоод (Innenvollmacht) бүрэн эрх, харин гуравдагч этгээдэд мэдэгдсэн бол гадаад (Außenvollmacht) бүрэн эрх гэх ангиллыг ХБНГУ-ын иргэний эрх зүйд ашиглаж байна.¹⁰

Төлөөлөгчийн хийсэн хэлцлийн үр дагавар төлөөлүүлэгчид үүсэхийн тулд төлөөлөгч нь дан ганц өөрийн хүсэл зоригийг илэрхийлсэн байх, төлөөлөл ил тод байх зарчмыг хангасан байхаас гадна "төлөөлөх бүрэн эрхтэй" байж үйл ажиллагаа явуулсан байх ёстой. Төлөөлөх бүрэн эрх гэдэг нь өөр нэг этгээдийг хүчин төгөлдөр төлөөлөх, төлөөлүүлэгчид үйлчлэл бий болох хүсэл зоригийг илэрхийлэх болон хүсэл зоригийн илэрхийллийг хүлээн авах эрх юм.¹¹ Мөн төлөөлөх бүрэн эрх нь нэг ёсондоо төлөөлүүлэгчийн бүрэн эрхийг хамгаалах явдал юм. Төлөөлөх бүрэн эрх нь хуулийн дагуу, хэлцлийн үндсэн дээр гэсэн хоёр төрөлтэй. Хуулиас үүдэх бүрэн эрхийн тухайд энэ нь төлөөлөх бүрэн эрх төлөөлүүлэгчийн хүсэл зоригоос үл хамаарах ба хуулиас шууд үүснэ.¹² Энэхүү судалгааны ажлын хувьд хэлцлийн үндсэн дээр төлөөлөх бүрэн эрхтэй холбоотой тул зөвхөн энэ агуулгыг цааш дэлгэрүүлнэ.

Итгэмжлэл (*letter of attorney; procuracy; trust; power of attorney*) – Төлөөлүүлэгч нь гуравдагч этгээдийн өмнө өөрийг нь бүрэн төлөөлөх эрх төлөөлөгчид олгосныг нотлох, баримт бичиг.¹³ Хэлцлийн дагуу төлөөлөх бүрэн эрхэд итгэмжлэл гэх ойлголт гарах нь мэдээжийн хэрэг. Итгэмжлэл буюу нэг талын хэлцлээр төлөөлөгч этгээдэд төлөөлөх эрх үүсэх бөгөөд харин тохиролцооны

⁹ Ц.Оюунчимэг, "Иргэний эрх зүйн харилцаа дахь төлөөлөл", *Хууль дээдлэх ёс сэтгүүл №1*, 2004, 26 дахь тал.

¹⁰ Hemmer/Wuest, Zivilrecht I (BGB AT/Vertraegliche Schuldverhaeltnisse) Rn.49

¹¹ Энх-Амгалангийн Байгал, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, (Улаанбаатар: Соёмбо, 2011), 244 дэх тал.

¹² Батаагийн Тэмүүлэн нар, *Иргэний эрх зүй ерөнхий анги, 2 дахь хэвлэл*, (Улаанбаатар: 2013), 216 дахь тал.

¹³ Бямбажавын Улаанбаатар, *Иргэний эрх зүйн тайлбар толь*, (Улаанбаатар: Арилдал, 2005), 68 дахь тал.



үүрэг үүсэхгүй тул энэ шинжээрээ бусдын нэрийн өмнөөс үйлдэл хийх зарим тодорхой төрлийн /даалгаврын гэрээ, комиссын болон зуучлалын гэрээ зэрэг/ гэрээнээс ялгаатай.¹⁴ Төлөөлүүлэгч өөрийнхөө нэрийн өмнөөс хэлцэл хийх бүрэн эрхийг өөр этгээд буюу төлөөлөгчид олгосон хууль зүйн үр дагавар бүхий үйлдэл буюу нэг талын хэлцлийг итгэмжлэл гэж нэрлэнэ.¹⁵ Итгэмжлэлийг хоёр талын гэрээгээр бус нэг талын хэлцлийн үндсэн дээр олгодог онцлогтой. Өөрөөр хэлбэл төлөөлөгч бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй. Гэхдээ бүрэн эрхийг хүлээн авахаас татгалзах эрхийг олгосон байна. Итгэмжлэл нь нэг талын хэлцэл болохынхоо хувьд хэлцэлд тавигддаг шаардлагыг хангах ёстой. Итгэмжлэлийг хуульд бичгээр хийхээр заасан эсхүл талууд бичгээр хийхээр харилцан тохиролцсон бол бичгээр хийнэ. Бичгээр олгосон итгэмжлэлд гарын үсэг зурсан байх ба олгосон он, сар, өдрийг тусгана.

Итгэмжлэл нь хугацаатай болон хугацаагүй байна. Итгэмжлэлийн дээд хугацаа 3 жил, харин итгэмжлэлд хугацаа заагаагүй бол итгэмжлэгчид олгосон өдрөөс эхлэн нэг жилийн дотор хүчин төгөлдөр байх ба итгэмжлэл олгосон он, сар, өдрийг бичээгүй бол эрх зүйн баримт бичиг болж чадахгүй. Итгэмжлэлийг хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх, итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заана. Итгэмжлэл тодорхой нэр бүхий эзэнтэй, өөрөөр хэлбэл итгэмжлэгчийн овог нэр, бичигдсэн байх ёстой. Итгэмжлэл тодорхой хугацаатай, төлөөлөгчийн бүрэн эрх тодорхой тусгагдсан байна. Хуулиар онцгойлон тогтоогоогүй тохиолдолд итгэмжлэлийг ямар агуулгаар олгох нь түүнийг олгож байгаа этгээдийн өөрийнх нь шийдвэрлэх асуудал юм. Хуулийн этгээдийн олгосон итгэмжлэлд дээрх шаардлага тавигдахаас гадна тухайн итгэмжлэлд хуулийн этгээдийн эрх баригчийн гарын үсэг, тамга, тэмдэг нь дарагдсан байх бөгөөд хэрвээ хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээн авах, бусдад шилжүүлэх, захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэлд эрх баригчаас гадна нягтлан бодогчийн гарын үсэг зурсан байх хууль зүйн шаардлага бий.¹⁶ Үүнээс харвал иргэний хуульд зөвхөн бичгээр олгосон итгэмжлэлд тавигдах шаардлагыг тодорхой заасан ч амаар олгосон итгэмжлэлийн шаардлагатай холбоотой зохицуулалт байхгүй байна. Итгэмжлэлд төлөөлөх эрх олж авч буй этгээдийн хийж болох үйлдлийн хүрээ хязгаар, эрхийг тодорхой зааж өгөх нь зүйтэй байдаг.¹⁷ Төлөөлөгчид олгож буй бүрэн эрхийг агуулга, хэмжээгээр нь гурван төрөлд хуваана. Үүнд:

Ерөнхий итгэмжлэл – Тодорхой хугацааны туршид янз бүрийн хэлцэл ба хууль зүйн бусад үйлдэл хийхэд эл итгэмжлэлийг олгоно. Жишээлбэл, хуулийн этгээдийн салбарын удирдлагад олгох итгэмжлэл.

Хэд хэдэн нэг төрлийн хэлцэл буюу хууль зүйн бусад үйлдэл хийхэд олгох тусгай итгэмжлэл- Ийм итгэмжлэлийг шүүх, арбитрад төлөөлөх, ачаа тээвэрлэгчээс бараа материалын үнэт зүйлсийг хүлээн авах зэрэг итгэмжлэл.

¹⁴ Шихихутаг Их сургууль, Иргэний эрх зүйн ерөнхий анги, (Улаанбаатар: Мөнхийн Үсэг, 2021), 197 дахь тал.

¹⁵ Түмэнжаргалын Мэндсайхан, Гэрээний эрх зүй, (Улаанбаатар: ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, 2021), 138 дахь тал.

¹⁶ Ц.Оюунчимэг, "Иргэний эрх зүйн харилцаа дахь төлөөлөл", *Хууль дээдлэх ёс сэтгүүл* №1, 2004, 27 дахь тал.

¹⁷ Энх-Амгалангийн Байгал, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, (Улаанбаатар: 2009), 242 дахь тал.



Тодорхой хэлцэл буюу хууль зүйн бусад үйлдэл хийлгэхийн тулд олгосон нэг удаагийн итгэмжлэл.¹⁸

Итгэмжлэлийг ерөнхий, тусгай болон тодорхой төрлийн олон хэлцэлд хамаарах итгэмжлэл, ганцаарчилсан ба хамтран төлөөлөхөд чиглэсэн итгэмжлэл, үндсэн ба дэд итгэмжлэл, өндөр настныг асран тэтгэх итгэмжлэл, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэл хэмээн ангилан авч үздэг байна.

Ерөнхий, тусгай болон тодорхой төрлийн олон хэлцэлд хамрагдах итгэмжлэл: Итгэмжлэлийн агуулга нь төлөөлүүлэгчийн илэрхийлсэн хүсэл зоригоор тодорхойлогдоно. Итгэмжлэлийг тодорхой нэг хэлцлийг хийхэд зориулан (тусгай), нэг төрлийн олон хэлцэл хийлгэхээр ерөнхий олгож болно. Тухайлбал, Компанийн гүйцэтгэх удирдлагаас өдөр тутмын үйл ажиллагааг нь түргэн шуурхай, хэвийн явуулах үүднээс салбар нэгжүүдэд ерөнхий итгэмжлэл олгож болно.

Ганцаарчилсан ба хамтран төлөөлөхөд чиглэсэн итгэмжлэл: Дээрхээс гадна итгэмжлэл олгогч нь төлөөлөгчийн бие даан ганцаар эсвэл өөр этгээдтэй хамтарч хэлцэл хийхээр зааж, холбогдох итгэмжлэлийг олгож болно.

Үндсэн ба дэд итгэмжлэл: Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дахин цааш төлөөлөх бүрэн эрх олгох эрхтэй бол итгэмжлэлийг үндсэн ба дэд итгэмжлэл гэж ялгана. Дэд итгэмжлэл олгож болох эсэх тухай үндсэн итгэмжлэлийн агуулга тусгасан байх шаардлагатай ба дэд төлөөлөгч энд мөн л төлөөлүүлэгчийн өмнөөс хэлцэл хийх эрхтэй болно. Жишээлбэл, "И" банк гүйцэтгэх захирал нь өөрийн орон нутагт байрлах салбарын захирал төлөөлөх эрхийг шилжүүлэх боломжтой итгэмжлэл өгч улмаар салбарын захирал нь тодорхой төрлийн ажил гүйцэтгүүлэхээр итгэмжлэл өгч болно. Энэ тохиолдолд үндсэн итгэмжлэл нь "И" банкны гүйцэтгэх захирлаас салбарын захиралд өгсөн итгэмжлэл бол дэд итгэмжлэл нь салбарын захирлаас ажилтанд олгож байгаа итгэмжлэл юм.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь итгэмжлэл: Аливаа эрх зүйн маргааныг шүүхэд хянан шийдвэрлэхэд бусдыг төлөөлж буй этгээд нь үйлчлүүлэгчээс олгосон холбогдох итгэмжлэлтэй байж, бусдын эрх, үүргийг шүүхэд төлөөлөн хэрэгжүүлнэ. Өмгөөлөгч болон төлөөлөгчийн эрх, үүрэг болон итгэмжлэлд тавигдах шаардлагыг ИХШХТХ-ийн 32-оос 36 дугаар зүйлд тусгайлан зохицуулсан байдаг. Жишээлбэл, "А" ХХК өөрийн компанийн хөндөгдсөн эрх ашгийг сэргээх үүднээс өмгөөлөгч Н-тэй гэрээ байгуулж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд компанийг төлөөлүүлж болно.¹⁹

Бүрэн эрхийг хэрэгжүүлэх баримт бичиг болсон итгэмжлэлийг буруугаар ашиглах тохиолдол байдаг. Төлөөлөгч төлөөлүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлсэн эсэх нь бүрэн эрхийг гадаад харилцаанд хэрэгжүүлэхэд төдийлөн ач холбогдолгүй ч дотоод харилцаанд чухал байдаг. Төлөөлөгч төлөөлүүлэгчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүрэг зааврыг зөрчих зэргээр биелүүлэхгүй байх нь нөгөө талд учирсан хохирлыг төлөөлүүлэгчийн өмнөөс

¹⁸ Содовсүрэнгийн Нарангэрэл, Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг: хууль зүйн нэр томъёо ба ухагдахуунтай (Анхны хэвлэл), (Улаанбаатар: Адмон, 2021), 193 дахь тал.

¹⁹ Батаагийн Тэмүүлэн, Дагвадоржийн Энхзул, Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, (Улаанбаатар: Мөнхийн Үсэг, 2010) 175 дахь тал.



мэдэгдээгүй боловч, төлөөлөх бүрэн эрхтэй мэтээр бусдын нэрийн өмнөөс үйлдэл хийх тохиолдол бий. Энэ тохиолдолд итгэмжлэл бий хэмээн итгэж найдсан хэлцлийн нөгөө тал болох этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалах шаардлага бий болдог²³. Төлөөлөгч өөрт нь бүрэн эрх олгосон гэж ойлгоод төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй тодорхой гэрээ байгуулах үйлдэл хийх явдал цөөнгүй тохиолдоно. Энэ үед төлөөлүүлэгч ба төлөөлөгч хоёрын хоорондын харилцаа, хамтын ажиллагааны тодорхой хугацааны өрнөлөөр төлөөлүүлэх ойлголт төрүүлсэн эсхүл төлөөлснийг дуугүй байдал, эс үйлдэхгүйгээр хүлээн зөвшөөрсөн нөхцөл байдал чухал ач холбогдолтой. Нөгөө талаас гуравдагч этгээд төлөөлөгчийн төлөөлөх бүрэн эрхтэй гэдэгт итгэж шударгаар хэлцэл байгуулсан байдаг. Итгэмжлэл нь үндсэн хэлцэлтэй дуусгавар болох талаараа холбоотой байдаг зэргээс хамаараад харилцагч тал буюу гуравдагч этгээдэд нэгэнт олгосон бүрэн эрх хүчин төгөлдөр, хэвээр байгаа эсэхийг мэдэхэд хүнд байдаг. Харин итгэмжлэл олгогч энэ тухайгаа гадаад харилцаанд ил болгох ямар нэг үйлдэл хийсэн бол үүнд итгэх гуравдагч этгээдийн итгэл үнэмшил хуулиар хамгаалагддаг бөгөөд энэ талаар Иргэний хуулийн 65.1-д хуульчилсан.

Төлөөлүүлэгч бүрэн эрх олгоогүй ч төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг нөгөө этгээдэд өгөхөөр нөхцөл бүрдүүлснээс төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон түүнийг шударгаар төлөөлсөн бөгөөд нөгөө тал нь үүнд итгэн хэлцэл хийсэн хоёр урьдчилсан нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Эдгээр тохиолдолд итгэмжлэл олгосон гэж итгэсэн этгээдийн итгэл, үнэмшлийг хамгаалах үүднээс хүчин төгөлдөр төлөөллийн харилцаанаас үүдэх үүрэгтэй яг адилхан эрх үүрэг төлөөлүүлэгчид үүснэ. Төлөөлөх үйлдэл хийсэн этгээдийн итгэл үнэмшил Иргэний хуулийн 65.1-ээр хамгаалагдсан бол нөгөө талын итгэл үнэмшлийг хамгаалах нь нийт төлөөллийн заалтуудын зорилгоос урган гарч байдаг²⁴. Энэхүү зорилго нь хэлцлийг биечлэн хийвэл зохих байтал бусад этгээдэд төлөөлөх бүрэн эрхээ дамжуулан түүгээрээ хуульд заасан үйлдэл хийсэн нөхцөлд гуравдагч этгээдийг хамгаалах нь шударга гэж тайлбарладаг. Тиймээс төлөөлүүлэгч анхаарал болгоомжгүйн улмаас бусдад төлөөлөх эрхтэй мэт ойлголтыг төрүүлсэн учраас хэлцлийн үр дагаврыг өөрөө хариуцах хэрэгтэй гэсэн санаатай.

Энэ зарчмын үүднээс үзвэл итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдол нь дараах гурван бүрэлдэхүүн хэсгийг хангаж байх шаардлагатай. Нэгдүгээрт бүрэн эрхтэй гэж таамаглахуйц бодит нөхцөл байдал бий болсон байх. Өөрөөр хэлбэл гадаад байдлын талаарх нөхцөл байдал буюу гаднаас харахад төлөөлөх бүрэн эрхтэй мэт бодит итгэл үнэмшил төрөх явдал. Хоёрдугаарт харагдах байдалд шударгаар итгэсэн байх буюу тэрхүү гадаад байдал, нөхцөл байдалд гуравдагч этгээд шударгаар итгэсэн байх шаардлагатай. Энэ нь дотроо хоёр агуулгыг илтгэнэ. Эхнийх нь гуравдагч этгээд үнэн сэтгэлээсээ итгэсэн байх буюу гаднах байдал нь төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгогдохоор байсан ч бодит байдал дээр төлөөлөх эрх байхгүй гэдэг үнэнийг мэдэж байсан буюу шударга бус гуравдагч этгээд биш байх. Удаах нь итгэлцэл нь хууль ёсны байх (гэм буруугүй байх) буюу төлөөлүүлэгчийг хохироож гуравдагч этгээдийг хамгаалж байгаа учраас гуравдагч этгээдийн төлөөлөх эрхтэй гэж итгэсэн нь хууль

²³ Мөн тэнд, 251 дэх тал

²⁴ Батаагийн Тэмүүлэн нар, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, (Улаанбаатар:2013), 226 дахь тал



ёсны биш бол болохгүй. Тиймээс дан ганц үнэн сэтгэлээсээ итгэсэн байх биш шударгаар гэм буруугүй байх шаардлагатай байна. Гуравдугаарт төлөөлүүлэгчид тодорхой хэмжээний гэм буруу байх шаардлагатай өөрөөр хэлбэл энэ нь бодит байдал дээрх хэлцэл хийх эрх бүхий этгээд болох төлөөлүүлэгчийг хамгаалах утгаараа зайлшгүй шалтгаан байгаа тохиолдолд л зөвхөн хариуцлага хүлээнэ гэх хариуцлагын зарчимд ач холбогдол өгөх байр суурьд үндэслэдэгт оршино.

Итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлыг гурван үйлдлээр тайлбарладаг. Эхнийх нь төлөөлүүлэгч төлөөлөгчид бүрэн эрх олгосон мэт ойлголт төрүүлснээр төлөөлөх бүрэн эрх үүсэх, хоёрт итгэмжлэлийг зөвшөөрсөн мэт дүр эсгэх, гуравт итгэмжлэл олгосон мэт дүр үзүүлж, хийсвэр ойлголт төрүүлэх үйлдлүүд багтдаг.

3. Монгол Улсын шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Хүснэгт 1. УДШ-ийн тогтоолд хийсэн судалгаа

№	Огноо, Хэргийн Дугаар	Маргааны төрөл	Иргэний хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тайлбарласан тайлбар
1.	2016.09.29 001/ХТ2016/00974 ²⁵	Ажил гүйцэтгэх гэрээ	Төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нь тухайн ХХК-г төлөөлөн үндсэн болон нэмэлт гэрээ, тооцоо нийлсэн акт зэргийг үйлдэж гарын үсэг зурж байснаас харвал тухайн ХХК төлөөлөх бүрэн эрхгүй этгээдэд төлөөлөх эрхтэй мэт ойлголтыг анхнаасаа өгсөн байна. Г.Т нь хариуцагч компанийг төлөөлөн үндсэн болон нэмэлт гэрээг байгуулж байсан, хоёр талын тооцоо нийлсэн баримт, уулзалтад оролцож байснаас үзэхэд төлөөлөх эрхтэй этгээд гэж үзэхээр байх ба 25 000 000 төгрөгийг Г.Т авсан, манай компани аваагүй гэх хариуцагчийн татгалзал үндэслэлгүй.
2.	2017.02.14 001/ХТ2017/00168 ²⁶	Банкны барьцаа	Төлөөлүүлэгч нь гэр бүлийн хамаарал бүхий этгээдэд иргэний үнэмлэхээ өгснөөр итгэмжлэл олгосон үйлдэл гэж үзэж, түүнийг Иргэний хуулийн 65.1-д зааснаар төлөөллийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Д.Ж эх Ш.А-ийн хүсэлтийг үндэслэн итгэмжлэл хийлгэхийг зөвшөөрч иргэний үнэмлэхээ ээждээ өгсөн үйл баримтын талаар хариуцагч маргаагүй байх тул Д.Ж-аас Ш.А-д олгосон итгэмжлэлийг Иргэний хуулийн 65.1-д зааснаар төлөөллийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

²⁵ УДШ-ийн 2016 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 001/ХТ2016/00974 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/1568

²⁶ УДШ-ийн 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 001/ХТ2017/00168 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/2104



3.	2017.6.23 001/ХТ2017/00881 ²⁷	Зээлийн гэрээ	"ЗМ" ХХК өөрийгөө төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг "НХ" ХХК-д баримт бичиг үйлдэх замаар өгсөн ба "НХ" ХХК тус баримт бичгийг үндэслээд банктай Барьцааны гэрээ байгуулсан байхад өөрийгөө төлөөлүүлэхээр ойлголт өгсөн этгээд болох "ЗМ" ХХК "НХ" ХХК-ийн төлөөлөх бүрэн эрхгүй байсныг ашиглан Барьцааны гэрээг хүчин төгөлдөр бусд тооцуулахаар шаардах эрхгүй юм.
4.	2017.11.14 001/ХТ2017/01415 ²⁸	Барьцааны гэрээ	Төлөөлөгч итгэмжлэл дээр заасан бүрэн эрхийг хэтрүүлэн хэрэглэсэн боловч төлөөлүүлэгч үүнийг мэдэж, зөвшөөрсөн мэт идэвхгүй үйлдэл гаргасан учир төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гэж үзэх нь үндэслэлгүй. Н.Б нь Р.Э-ыг иргэнээс зээл авахыг мэдэж, зөвшөөрөн, оронсууцны хамтран өмчлөгч нарт энэ талаар ойлгуулсан атлаа итгэмжлэлийн стандарт маягтад "банкны зээлийн барьцаа" гэж бичигдсэнийг ашиглан барьцааны гэрээ байгуулсан Р.Э-г иргэнтэй барьцааны гэрээ байгуулахад өөрийгөө төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гэж, улмаар түүний Ш.Б-тай байгуулсан гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй.
5.	2018.02.02 001/ХТ2018/00170 ²⁹	Ажил гүйцэтгэх гэрээ	Хоёр хуулийн этгээдийг төлөөлж гэрээнд гарын үсэг зурсан Г, Б нарын бүрэн эрхийн талаар компанийг төлөөлөх эрхгүй этгээд гэрээ байгуулсан гэх хариуцагчийн тайлбар, гомдол үндэслэлгүй байна.
6.	2018.05.24 001/ХТ2018/00848 ³⁰	Зээлээр худалдах худалдан авах гэрээ	Бүрэн эрхгүй төлөөлөгч нь өөрийгөө төлөөлүүлэгч компанийн ТУЗ-ын дарга гэж танилцуулж гарын үсэг зурсан компанийн тамга дарагдсан тул төлөөлөх эрхгүй гэж үзэж хэлцлийг хүчин төгөлдөр бусд тооцох боломжгүй.

²⁷ УДШ-ийн 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 001/ХТ2017/00881 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/2847

²⁸ УДШ-ийн 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 001/ХТ2017/01415 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/3322.

²⁹ УДШ-ийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 001/ХТ2018/00170 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/3812.

³⁰ УДШ-ийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 001/ХТ2018/00848 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/4553.



7.	2018.10.12 001/ХТ2018/01387 ³¹	Ажил гүйцэтгэх гэрээ	Хэлцэл байгуулагдсанаас хойш гэрээний гүйцэтгэлийг хүлээн авсан үйлдэл нь хүлээн зөвшөөрсөн үйлдэл гэж үзсэнээр Иргэний хуулийн 65.1 хэрэглэнэ. Ц.Х нь гэрээ байгуулснаас хойш буюу 2014.5.23-ны өдөр улсын бүртгэлд компанийн гүйцэтгэх захирлаар бүртгэгдсэн хэдий ч 2014.5.30-ны өдөр 350 000 000 төгрөгийг, 2014.6.9-ний өдөр 650 000 000 төгрөгийг гэрээний дагуу авснаар гэрээг хүлээн зөвшөөрсөн тул гэрээг байгуулах эрхгүй байсан гэх гомдол үндэслэлгүй.
8.	2019.03.14 001/ХТ2019/00354 ³²	Ажил гүйцэтгэх гэрээ	Борлуулалтын албаны дарга үйлдвэрийн газрыг төлөөлөх бүрэн эрхгүй байсан ч түүний байгуулсан гэрээг тус үйлдвэрийн газрын захирал баталсан байх тул зохигчийн хоорондох ажил гүйцэтгэх гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзэхгүй.
9.	2019.05.24 001/ХТ2019/00769 ³³	Худалдах худалдан авах гэрээ	Төлөөлүүлэгч компанийн ажилчин болох төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн тооцоо нийлсэн баримтад гарын үсэг зурсан учир Иргэний хуулийн 65.1-д зааснаар төлөөлүүлэгчид хариуцлага үүснэ. Цахилгаан шатны давхрын түвшин болон хаалганы порем зөрүүтэй байдлыг засварласны дараа хүлээн авахад бэлэн гэх хариуцагч "ЧС" ХХК-ийн менежер, тооцооны баталгаа гаргасан нягтлан бодогч нар нь хуулийн этгээдийг төлөөлөх эрхгүй гэх хариуцагчийн тайлбар Иргэний хуулийн 65.1-д заасан зохицуулалтын дагуу хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн шүүхийн дүгнэлт буруу биш байна.
10.	2020.02.18 001/ХТ2020/00110 ³⁴	Худалдах худалдан авах гэрээ	Төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн байгуулсан гэрээнээс үүдэх үүргийг төлөөлүүлэгч нь төлөхөө хүлээн зөвшөөрсөн үйлдэл гаргасан учир Иргэний хуулийн 65.1-д зааснаар төлөөлүүлэгч хариуцлага хүлээнэ. 2017.6.24-ний өдрийн "...үлдэгдэл 33,893,520 төгрөгийг төлөх..." тооцоо нийлсэн баримтад Б.Эрдэнэболд гарын үсэг зурсан боловч хожим нь "Б"ХХК 2018.10.17-ны өдрийн 07/18 тоот албан бичгээр уг төлбөрийг төлөх талаар мэдэгдэж байсан баримтаар хариуцагч үүргээ хүлээн зөвшөөрсөн нь тогтоогдсон байна.

³¹ УДШ-ийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 001/ХТ2018/01387 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/5000.

³² УДШ-ийн 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 001/ХТ2019/00354 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/6113.

³³ УДШ-ийн 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 001/ХТ2019/00769 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/6404.

³⁴ УДШ-ийн 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 001/ХТ2020/00110 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/6597.



11.	2020.4.16 001/ХТ2020/00196 ³⁵	Хөдөлмөрийн маргаан	Улсын бүртгэлд төлөөлөх эрхгүй этгээд нь тус компанийн гүйцэтгэх захирал, итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр бүртгэгдсэн эсэх нь тодорхой бус хэдий ч компанийг төлөөлөн үйл ажиллагаа явуулж, шийдвэр гаргаж байсан нь тогтоогдсон байхад түүний бүрэн эрхийг үгүйсгэж болохгүй болно.
12.	2020.11.10 001/ХТ2020/00777 ³⁶	Эзэмших эрх шилжүүлэх гэрээ	Төлөөлөх эрхийг итгэмжлэлд тодорхой тусгаагүй ч төлөөлүүлэгч төлөөлөгчид эрх олгох гэсэн хүсэл зориг нь батлагдаж байна. Түүнчлэн, хэрэгт авагдсан баримтаас үзвэл, А.Ц-гийн бүрэн эрх нь Б.Одонгэрэлийн 2012.11.15-ны өдөр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үүссэн байх бөгөөд А.Ц- нь итгэмжлэлээр олгосон үйл ажиллагааг 2013.7.31-ны өдөр биечлэн гүйцэтгэсэн нь тогтоогджээ. Газар эзэмших эрх шилжүүлэх хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийхийг хуулиар хориглоогүйгээс гадна төлөөлөгчөөр дамжуулан хийж болохгүй хэлцэлд хамаарахгүй байна.
13.	2021.4.13 001/ХТ2021/00377 ³⁷	Зээлийн гэрээ	Төлөөлүүлэгч итгэмжлэлээр дамжуулан төлөөлөгчид эрх олгосон ч түүний хэлбэрийн шаардлага дээр маргаан үүссэн ба Иргэний хуулийн 65.1-ийн дагуу төлөөлөх эрхтэй гэж тооцох нь зөв.
14.	2023.5.30 001/ХТ2023/00097 ³⁸	Худалдах худалдан авах гэрээ	Хариуцагч "Ж" ХХК-ийг төлөөлөн Г гэрээнд гарын үсэг зурж, бараа хүлээн авсныг баталгаажуулсан бичгийн баримт үйлдсэн байх тул компанийг төлөөлөх эрхгүй этгээдтэй хэлцэл хийсэн гэх хариуцагчийн татгалзал үндэслэлгүй.

Дээрх 14 шийдвэрийн хувьд Иргэний хуулийн 65.1-г хэрэглэхдээ хуульд заасан урьдчилсан нөхцөлийг хангасан эсэх талаар тайлбарлаагүй. Мөн сүүлийн 3 жил орчмын хугацаанд Иргэний хуулийн 65.1 дэх хэсгийг үндэслэл болгон шийдсэн УДШ-ийн тогтоол байхгүй байна. Өөрөөр хэлбэл бүрэн эрхтэй гэх ойлголт өгсөн нөхцөл бүрдүүлсэн гэж юуг ойлгох, тийнхүү төлөөлөгч нь шударгаар төлөөлж байгааг хэрхэн ойлгох, бүрэн эрхгүй байсныг ашиглах гэх мэтийг тайлбарлахгүйгээр шийдвэрлэжээ. Онолын хувьд бол зарим судлаачид Иргэний хуулийн 65.1-г итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдолтой холбож тайлбарладаг. Үүн дотроо төлөөлүүлэгч төлөөлөгчид бүрэн эрх олгосон мэт ойлголт төрүүлснээр төлөөлөх бүрэн эрх үүсэх, итгэмжлэлийг зөвшөөрсөн мэт

³⁵ УДШ-ийн 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 001/ХТ2020/00196 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/6672.

³⁶ УДШ-ийн 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 001/ХТ2020/00777 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/7145.

³⁷ УДШ-ийн 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 001/ХТ2021/00377 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/7479.

³⁸ УДШ-ийн 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 001/ХТ2023/00097 тогтоол, legaldata.mn/shiidver/irgen/view/9461?whr=s.



дүр эсгэх, итгэмжлэл олгосон мэт дүр үзүүлж, хийсвэр ойлголт төрүүлэх талаар аль онолыг хэрхэн хэрэглэсэн эсэх нь ч тусгагдаагүй байна. Ер нь бол эдгээр онолыг манай шүүгчид бараг хэрэглэдэггүй гэж дүгнэхэд хилсдэхгүй. Учир нь онолын тайлбар нь практик дээр хэрэгжихгүй байна.

Мөн Иргэний хуулийн 68.1 болон итгэмжлэлийг зөвшөөрсөн мэт дүр эсгэх тохиолдлыг хэрхэн ойлгож, ялгаж байгаа эсэх нь тодорхой бус байна. Үүнээс үзвэл тус 65.1-ийн агуулга нь хуульд тусгагдсан ойлголтдоо тохирсон онолыг өөртөө агуулахгүй байна. Мөн түүнчлэн хууль хэрэглээний хувьд хэргийг шийдэж буй эрх бүхий этгээдүүд ч тэрхүү зохицуулалтыг хэрхэн хэрэглэж шийдэх эсэхээ мэдэхгүй байх хандлагатай байна.

III. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1. БНСУ-ын итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлын онолын ойлголт, эрх зүйн зохицуулалт

БНСУ-ын хувьд Герман Францын тогтолцоог судлаад холимог шинэ тогтолцоог бүрэлдүүлсэн улс юм. 1948 онд БНСУ-ыг төвхнүүлснээс хойш өрнөдийн эрх зүйн соёл, үзэл санааг шууд, чөлөөтэйгөөр авч хэрэглэж эхэлсэн юм. Японы эрх зүйгээс түүний мөн чанар болсон зарчим, үзэл баримтлалыг нь Германы эрх зүйгээс ч мөн үндсэн зарчим, үзэл баримтлалаас нутагшуулахаар болсон. Үүний үр дүнд солонгосын эрх зүй нь Японы эрх зүйгээс илүүтэйгээр Германы эрх зүйн хэв маягтай болсон гэж үздэг.³⁹ 1948 оны 7 дугаар сарын 17-ны өдөр улсынхаа тусгаар тогтнолыг зарлаж анхны Үндсэн хуулиа баталсан бөгөөд Иргэний хуулиа 1958 онд баталж байжээ. БНСУ-ын Иргэний хууль дахь тогтолцоо нь Япон улсын холбогдох зохицуулалтаас уламжлалтай бөгөөд уг уламжлан авсан зохицуулалт нь ХБНГУ болон Францын тогтолцоог холимог байдлаар шинэчлэн боловсруулсан тогтолцоо болно.⁴⁰

БНСУ-ын Иргэний хуулийн 114–136 дугаар зүйлд төлөөлөлтэй холбоотой ойлголтыг зохицуулсан байдаг. Хуулийн дагуу хувь хүн эрх зүйн харилцаанд төлөөлөгчөөр дамжуулан оролцдог нь өнөө үед цаг хугацаа, эдийн засаг, нийгмийн харилцаанд ихээхэн ач холбогдолтой байна. Ийнхүү төлөөлөлд иргэний эрх зүйн үндсэн үзэл баримтлал болох хувийн бие даасан байдлын зарчим хэрэгждэг. Төлөөлөгч болон төлөөлүүлэгч хоорондын харилцаа нь итгэлцлийн зарчим дээр тулгуурладаг тул практик дээр асуудал үүсэх эрсдэлтэй байдаг.⁴¹ Иргэний хуульд тусгагдсан төлөөллийн тухай зохицуулалтууд нь тэдгээр асуудлуудыг шийдвэрлэх, төлөөллийн харилцааг аюулгүй байлгах үндэс суурийг тавих зорилготой юм.

Төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь төлөөлүүлэгчид бий болно. Төлөөлөх эрх нь гагцхүү төлөөлүүлэгч нь бүрэн

³⁹ Күүкмин Их Сургууль, *Солонгосын эрх зүйн удиртгал* 1, 2012, 101 дэх тал.

⁴⁰ Үсүй Ютака, *Герман улс дахь итгэмжлэл олгосон мэт тооцох хэлцлийн тухай үзэл хандлага* *Rechtsgeschäftstheorie-ийн сэргэлт*, 2006, 16 дахь тал. <https://www.ritsumei.ac.jp/acd/cg/law/lex/06-6/usui.pdf> (Сүүлд үзсэн: 2026.03.06)

⁴¹ Ким Дун Хүн, Ан Гён Хи, Ким Сү Жон, *Иргэний эрх зүйн ойлголт*, (3 дахь хэвлэл), 2019, 47 дахь тал.



эрх олгосноор үүснэ. Бүрэн эрх олгосныг батлах баримт бичгийг итгэмжлэл гэж нэрлэнэ. Энэхүү итгэмжлэлд төлөөлөгчийн бүрэн эрх, тэрхүү бүрэн эрхийн хүрээ, агуулга тусгагддаг. Төлөөлөх бүрэн эрхийн хүрээг тодорхой зааж өгөөгүй тохиолдолд доорх хуульд заасан зарчмыг баримтална. Үүнд хамгаалах, хадгалах үйлдэл, төлөөллийн зорилго болсон зүйлийн шинж чанарыг өөрчлөхгүй хийсэн үйлдэл⁴² байна. Өөрөөр хэлбэл төлөөлөгчийн үйлдэл нь төлөөлүүлэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах эсхүл түүнийг хадгалах ёстой. Төлөөллөөс үүсэх эрх зүйн үр дагавар нь ямагт төлөөлүүлэгчид ашигтай буюу түүний түүний эрх зүйн байдлыг дордуулж болохгүй.

Худалдааны эрх зүйд төлөөлөх бүрэн эрхийг итгэмжлэл олгох хэлбэрээр олгодог ч үүнээс гадна бүрэн эрх олгох хэлбэрүүд байдаг. Тамга тэмдэг, баталгааны баримт, хувийн нэрийн тамга гэх мэтийг өгч буй төлөөлүүлэгчийн үйлдэл нь бүрэн эрх олгож байгаа хэлбэр. Итгэмжлэл нь төлөөлөх бүрэн эрхтэй гэх нотлох баримт бөгөөд энэхүү зөвшөөрөл байхгүй бол бүрэн эрхгүй этгээдийн төлөөлөл үүснэ.⁴³ Төлөөллийг бүрэн эрхтэй төлөөлөгч, бүрэн эрхгүй төлөөлөгч гэж ерөнхийд нь ангилдаг. Төлөөлөгч бүрэн эрхтэй мэтээр бусдын нэрийн өмнөөс үйлдэл хийдэг. Ийнхүү төлөөлөх эрхгүй этгээдийн үйлдэлд шударгаар итгэж найдсан гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах шаардлага гардаг.

Итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдол (外觀) нь бүрэн эрхгүй төлөөлөгч болон төлөөлүүлэгчийн хооронд төлөөллийн харилцаа байгаа эсэхийг дүгнэх боломжтой тодорхой нөхцөл байдал үүссэн тохиолдолд иргэний хуулиар хариуцлагыг төлөөлүүлэгчид хүлээлгэж, гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах зорилготой ойлголт юм. Итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлын хувьд гурван тохиолдлыг хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

1. Төлөөлөх бүрэн эрх олгосон тухай гуравдагч этгээдэд мэдэгдсэнээр үүсэх тохиолдол (125 дугаар зүйл)
2. Төлөөлөх эрхтэй боловч төлөөлөх эрхийнхээ хүрээнээс гадуур төлөөлөх тохиолдол (126 дугаар зүйл);
3. Төлөөлөгчийн бүрэн эрх дууссаны дараа төлөөлөх эрхээ хэрэгжүүлэх тохиолдол (129 дугаар зүйл)

Төлөөлөгч болон төлөөлүүлэгчийн хооронд эдгээр харилцааны аль нэг нь байгаа бол тэрхүү үйлдэлд гуравдагч этгээд шударгаар итгэн хэлцэл байгуулсан тохиолдолд төлөөлөх эрхгүй этгээдийн хийсэн үйлдэл нь төлөөлөлтэй адил байдлаар тооцогдоно.

⁴² БНСУ-ын Иргэний хуулийн 118 дугаар зүйл, [View E-book | Statutes of the Republic of Korea](#) (Сүүлд үзсэн: 2026.03.06)

⁴³ Су И На, Төлөөллийн эрх зүйн ойлголт, онолын тайлбар, 2008. <https://desert.tistory.com/593?fbclid=IwAR3Q5Hq4XimUmJKpc2k7q05xPghZljXSQYlJyxNAkaxafirjTtNKh0qAH8> (Сүүлд үзсэн: 2026.03.06)

Төлөөлөх эрхийг хэтрүүлэх (126-р зүйл)

Төлөөлөгч нь эрхээ хэтрүүлсэн тохиолдолд гуравдагч этгээд бүрэн эрхтэй гэж үзэх үндэслэл бүхий шалтгаан байгаа бол төлөөлүүлэгч уг үйлдлийн хариуцлагыг хүлээнэ. 126 дугаар зүйлийг тогтоохын тулд дараах гурван урьдчилсан нөхцөлийг хангасан байх ёстой.

- Төлөөлөгч бүрэн эрхтэй байх
- Төлөөлөгч бүрэн эрхээ хэтрүүлсэн үйлдэл хийх
- Гуравдагч этгээд шударгаар итгэж хэлцэл байгуулсан байх

Бодит практик дээр бүрэн эрхээ хэтрүүлэх ойлголт хамгийн их гардаг. Энэ нь төлөөлүүлэгч тодорхой хүрээнд бүрэн эрхийг олгосон байхад төлөөлөгч нь бүрэн эрхийн хүрээнээс хэтэрсэн төлөөллийг гүйцэтгэх явдал юм. Эдгээр тохиолдлуудад төлөөлөгч болон гуравдагч этгээдийн эрх ашгийг хэрхэн зохицуулах вэ гэдэг нь чухал. Ингэхдээ иргэний хуульд "Шударгаар төлөөлөх" гэсэн агуулгыг гол шалгуур болгон шийддэг байна.⁴⁷ Төлөөлөгч нь төлөөлөх эрхийг хэтрүүлэн эрх зүйн үйлдэл хийсэн нь гуравдагч этгээд тухайн үйлдлийг хийх эрхтэй гэж итгэхүйц үндэслэл бүхий шалтгаан үүссэн бол төлөөлүүлэгч нь тухайн үйлдэлд хариуцлага хүлээнэ. Тус зохицуулалтыг хэрэглэхдээ нэн түрүүнд гуравдагч этгээдийн шударгаар итгэсэн байх явдлыг чухалчилдаг. Өөрөөр хэлбэл гуравдагч этгээд төлөөлөх бүрэн эрхээ хэтрүүлсэн этгээдийн үйлдэлд итгэхүйц үндэслэл бүхий шалтгаан байх ёстой. Тэрхүү нөхцөлийг харгалзан үзэх нь энэ ойлголтын гол агуулга юм.

Төлөөлөх эрх дуусгавар болсны дараа төлөөлөх (129-р зүйл)

Иргэний хуульд заасан төлөөлөх эрх дуусгавар болсны дараа төлөөлсөн тохиолдолд төлөөлөх эрхтэй гэж тооцохын тулд дараах 3 урьдчилсан нөхцөлийг хангасан байна. Үүнд:

- Төлөөлөх эрх дуусгавар болсон байх
- Төлөөлөх эрхийнхээ хүрээнд төлөөлж байсан байх
- Гуравдагч этгээд шударгаар итгэж хэлцэл байгуулсан байх⁴⁸

Итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлыг бүрэн эрхгүй этгээдийн төлөөлөл эсхүл эрх бүхий этгээдийн төлөөлөл гэж ангилах нь одоог хүртэл судлаачдын дунд маргаантай байдаг. Дийлэнх судлаачдын үзэл баримтлалыг харвал бүрэн эрхгүй этгээдийн төлөөлөлд хамааруулдаг байна. Итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлын хувьд илэрхийллийн дотоод болон гадаад харилцаа яригддаг. Өөрөөр хэлбэл, 125-р зүйлийн хувьд дотоод харилцаа байхгүй ч төлөөлүүлэгчээс гуравдагч этгээдэд хандсан гадаад харилцаа байна. 126-р зүйлийн тухайд дотоод харилцаа бүрэн эрхээр тодорхой хүрээнд багтдаг бол гадаад харилцаа нь энэ хүрээнээс хэтэрдэг. Харин дотоод харилцаа хугацаа дуусгавар болсон ч гадаад харилцаанд тэрхүү хугацаа дуусаагүй тохиолдолд 129-р зүйл хамаарна. Итгэмжлэл

⁴⁷ Ким Дун Хүн, Ан Гён Хи, Ким Сү Жоң, Иргэний эрх зүйн ойлголт, гуравдугаар хэвлэл, 2019, 47 дахь тал

⁴⁸ Төлөөлөх эрх дуусгавар болсны дараа төлөөллийн тухай жишээн дээрх тайлбар, <https://blog.naver.com/byg416/221984500184> (Сүүлд үзсэн: 2026.03.06)



олгосон мэт тооцох тухай тохиолдол гэдэг нь төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн үйлдэлд шударгаар итгэсэн гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахын тулд төлөөлөх эрхгүй этгээдийг төлөөлөх эрхтэй мэтээр тооцдог онол юм.⁴⁹

2. Харьцуулсан судалгааны үр дүн

БНСУ-ын эрх зүйн тогтолцооны онцлог болон төлөөлөх бүрэн эрхгүй этгээд болон гуравдагч этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг авч үзлээ. БНСУ-ын иргэний эрх зүй дэх итгэмжлэл олгосонд тооцох тухай ойлголт нь төлөөлөх эрх олгосон гэж үзэх тохиолдол юм. Энэ нь үндсэн гурван тохиолдлоор илэрдэг байна. БНСУ-ын Иргэний хуулийн 129 дугаар зүйлд заасан төлөөлөх эрх дуусгавар болсны дараа төлөөлөх тухай зохицуулалт нь манай улсын төлөөлүүлэгч төлөөлөгчид бүрэн эрх олгосон мэт ойлголт төрүүлснээр төлөөлөх бүрэн эрх үүсэх онолын итгэмжлэл хүчин төгөлдөр бус болсон байхад төлөөлөх гэх агуулгатай дүйж байна. Өөрөөр хэлбэл нэгэнт олгогдсон байсан төлөөлөх эрх дуусгавар болсны дараа төлөөлөх тохиолдол нь хоёр улсын аль алинд нь байдаг байна.

Харин төлөөлөх бүрэн эрх олгосон мэт ойлголт төрүүлэх нөхцөлийг БНСУ-ын хуульд төлөөлүүлэгч гадаад харилцаанд буюу гуравдагч этгээдэд хандаж илэрхийлдэг байхад манай улсын хувьд дотоод харилцаа буюу төлөөлүүлэгч болон төлөөлөгч хоёрын хоорондох харилцааг тусгажээ. Мөн үлдсэн нэг ойлголт нь төлөөлөх бүрэн эрхээ хэтрүүлэх явдал юм. Энэ нь БНСУ-ын Иргэний хуулийн 126 дугаар зүйлд тусгагдсан байна. Өөрөөр хэлбэл төлөөлөх эрхтэй этгээд эрхийнхээ хүрээ хязгаараас давсан эрх зүйн үйлдлийг гуравдагч этгээдтэй байгуулсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар хуульчилсан байна. Харин энэхүү зохицуулалт нь манай улсын хуульд тусгагдаагүй. Бодит практикт ийм нөхцөл байдал бий болсон ч түүнийг хэрхэн шийдвэрлэж байгаа нь эргэлзээтэй.

БНСУ-ын хувьд төлөөлөх эрхтэй гэж хэлцэл байгуулсан гуравдагч этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалах тухай ойлголт нь гурав хуваагддаг бөгөөд тус бүрийн агуулгыг шингээж хуульдаа тусгасан байна. Өөрөөр хэлбэл тусдаа гурван заалт хэрэгждэг гэсэн үг. Харин манай улсын хувьд Иргэний хуулийн 65.1-т заасан агуулгыг гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалсан зохицуулалт гэж үздэг. Тийнхүү итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлыг гурван хэсэгт хувааж байгаа ч бүрэн эрх олгосон мэт тооцох тохиолдлыг нэгэнт олгосон бүрэн эрх, огт олгогдоогүй бүрэн эрх гэж хуваах нь мөн чанартаа дөрвөн агуулгыг ч тусгаж байгаа мэт. Эдгээр ойлголтыг манай улсын хувьд ганц заалтаар зохицуулна гэдэг хууль хэрэглээ болоод агуулга зүйн хувьд бэрхшээлтэй байна гэж үзлээ.

БНСУ нь Герман болон манай улсад хэрэгждэг тогтолцооноос өөр тогтолцоог ашигласан. БНСУ-ын хувьд итгэмжлэл олгосон мэт тооцож буй гурван тохиолдол нь цэгцтэй бөгөөд ойлгомжтой байна. Мөн БНСУ-д итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлуудын хувьд гол зарчим нь гуравдагч этгээд тухайн хэлцэлд төлөөлж байгаа этгээдэд шударгаар итгэсэн байхыг шаарддаг. Харин манай улсад хэрэглэгддэг *Duldungsvollmacht* болон *Anscheinsvollmacht* нь хэрэглэхэд

⁴⁹ Ким Сан Жүн, *Төлөөллийн тогтолцоо ба гуравдагч этгээдийн хамгаалалт*: Төлөөлөх эрхийг урвуулан ашиглах ба итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлыг анхаарах нь өгүүлэл, 10 дахь тал



төвөгтэй юм. Учир нь уг хоёр ойлголт нь ерөнхий зарчмаас урган гардаг тул практик дээр ашиглахад манай улсад тохиромжтой бус байна.

Иргэний хуулийн 65.1-д заасан гурван тохиолдлын нэг болох төлөөлүүлэгч бүрэн эрх олгосон мэт ойлголт төрүүлэх тохиолдол нь нэгдүгээрт огт олгогдоогүй бүрэн эрх, хоёрдугаарт олгогдсон бүрэн эрх хүчин төгөлдөр бус болсон гэх хоёр тохиолдлыг багтаадаг. БНСУ-ын 125 дугаар зүйлд заасан бүрэн эрх олгосон мэт ойлголттой адил үр дагаврыг Иргэний хуулийн 65.1 үүсгэж болохоор харагдаж байна. Ийнхүү манай улс нь шударгаар итгэн хэлцэл байгуулсан гуравдагч этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалах тухай ойлголтыг илүү боловсронгуй болгохын тулд БНСУ-ын зарим нэг зохицуулалтыг хуульдаа тусгах шаардлагатай гэж үзэж байна.

IV. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаараа төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлээс үүдэн гарах гуравдагч этгээдийг хамгаалах зохицуулалтуудын хэрэгжилт, итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлын онолын тайлбар, хуульд хэрхэн тусгагдсан байдал, бусад улсын хэрэгжилтийн талаар судалж, түүнд холбогдох тодорхой санал дэвшүүлэхийг зорьсон. Итгэмжлэлийг зөвшөөрсөн мэт дүр эсгэх тохиолдол, итгэмжлэл олгосон мэт дүр үзүүлж хийсвэр ойлголт төрүүлэх гэх тохиолдлуудыг манай улсын ИХ-ийн 65.1-ээр зохицуулах үндэслэл бүхий хэм хэмжээ байхгүй байна. Учир нь уг заалтад гагцхүү "шударгаар төлөөлөх" гэх агуулга тусгагдсан гэдэг утгаараа итгэмжлэл олгосон мэт тооцох онолтой холбож тайлбарлах гэсэн санаа буй. Гэтэл хэрхэн төлөөлүүлэгчийн эс үйлдэхүй болоод хүлээн зөвшөөрсөн нөхцөлийг зохицуулах талаар тусгагдаагүй байгаа тул гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалж чадах зохицуулалт эсэх нь эргэлзээтэй. Төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гуравдагч этгээдтэй хэлцэл байгуулсан үйлдэл нь төлөөлүүлэгчийн гэм буруу, үргэлжилсэн шинжтэйгээр байнга, давтагдан үйлдэгдсэн байхыг шаарддаг тул тодорхой тохиолдлуудад гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаална гэдэг бэрхшээлтэй.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Иргэний хуулийн 65.1-тэй холбоотой хэргүүдийг судлахад онолын тайлбарыг ашиглаж шийдсэн хэрэг байхгүй байсан. Өөрөөр хэлбэл Duldungsvollmacht, Anscheinsvollmacht тохиолдлууд нь практикт хэрэглэгдэхгүй байна. Үүнээс харвал тус итгэмжлэл олгосон мэт тооцох гурван тохиолдлыг ганц Иргэний хуулийн 65.1-д заасан агуулгаар тайлбарлах боломжгүй бөгөөд, онол нь практик дээр бодитойгоор хэрэгжихгүй байгааг шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ болон УДШ-ийн тогтоолд хийсэн судалгаанаас харж болно.

БНСУ нь гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах тухай зохицуулалтуудыг Иргэний хуулийн 125, 126, 129 дугаар зүйлүүдэд хуульчилсан бөгөөд манай зохицуулалттай ерөнхий байдлаар нэлээн төсөөтэй. Уг онолын гол шалгуур нь гуравдагч этгээд шударгаар итгэж хэлцэл байгуулсан байхыг шаарддаг. Иймд харьцуулсан судалгааны хүрээнд БНСУ-ын гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах тухай онол, онцгойлон бүрэн эрхээ хэтрүүлэхтэй холбоотой



зохицуулалтыг манай улс хуульдаа системчлэн ашиглавал зохилтой гэж үзэж байна.

Иргэний хуулийн 65.1-д заасан итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлын хувьд хамрах хүрээ, агуулга, болон хуульд заасан зохицуулалтыг илүү өргөжүүлэх шаардлагатай байна. Мөн одоо хэрэгжиж байгаа Иргэний хуулийн 65.1 нь Duldungsvollmacht буюу итгэмжлэлийг зөвшөөрсөн мэт дүр эсгэх тохиолдол, Anscheinsvollmacht буюу итгэмжлэл олгосон мэт дүр үзүүлж хийсвэр ойлголтын үндэслэл болохуйц хэм хэмжээ биш байна. Мөн чанартаа хуулийг иргэд ч уншаад ойлгох энгийн байх ёстой атал уг ойлголтыг хуульч судлаач, мэргэжлийн хүмүүс ч уншиж ойлгон хэрэглэхэд ээдрээтэй байна. Тийм учраас эдгээр тохиолдлууд шүүх дээр хэрэгжихгүй байгаа тул хэрэглэж болохуйц, бодитой тохиолдлуудыг тусгах шаардлагатай.

Ингэхдээ БНСУ-ын итгэмжлэл олгосон мэт тооцох тухай тохиолдлоос жишиг авч, өөрийн орны хууль тогтоомжийг илүү боловсронгуй болгохын тулд ажлын хүрээнд анхааралдаа авах шаардлагатай. Учир нь БНСУ-ын итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдол нь гагцхүү гуравдагч этгээд шударгаар итгэж үнэмшсэн байх зарчмаас үүдэлтэй байдаг. Тэрхүү итгэж үнэмших зохистой нөхцөл үүссэн л байвал бүрэн эрхтэй мэтээр тооцох буюу итгэмжлэл олгосон мэт тооцох нь зохистой.

Манай Иргэний хуулийн 65.1-д заасан зохицуулалт нь БНСУ-ын 125 дугаар зүйлтэй ерөнхий байдлаар адил төсөөтэй тул үлдсэн хоёр тохиолдлыг хэрхэн хэрэглэх вэ гэдэг нь чухал. БНСУ-ын 129 дүгээр зүйлд заасан төлөөлөх эрх дуусгавар болсны дараах төлөөллийг агуулгыг Иргэний хуулийн 65.1 болон 67.1 дэх заалтуудыг нэгтгэж, 126 зүйлд заасан бүрэн эрхээ хэтрүүлэх ойлголтыг Иргэний хуулийн 65.1 болон 68.1-г нэгтгэвэл ерөнхий агуулга нь тусгагдан, хэрэглэж болохоор байна.

Иймд цаашид БНСУ-ын иргэний хууль тогтоомж, иргэний эрх зүйд онолоор тайлбарлагддаг итгэмжлэл олгосон мэт тооцох тохиолдлуудаас жишиг авч, онцлог заалтуудыг өөрийн орны хууль тогтоомжийг илүү боловсронгуй болгох нь хууль хэрэглээний хувьд том ололт болох юм.

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Иргэний хууль, 2002 он.
2. УДШ-ийн 2016 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 001/ХТ2016/00974 тогтоол.
3. УДШ-ийн 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 001/ХТ2017/00168 тогтоол.
4. УДШ-ийн 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 001/ХТ2017/00881 тогтоол.
5. УДШ-ийн 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 001/ХТ2017/01415 тогтоол.
6. УДШ-ийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 001/ХТ2018/00170 тогтоол.
7. УДШ-ийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 001/ХТ2018/00848 тогтоол.
8. УДШ-ийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 001/ХТ2018/01387 тогтоол.



9. УДШ-ийн 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 001/ХТ2019/00354 тогтоол.
10. УДШ-ийн 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 001/ХТ2019/00769 тогтоол.
11. УДШ-ийн 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 001/ХТ2020/00110 тогтоол.
12. УДШ-ийн 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 001/ХТ2020/00196 тогтоол.
13. УДШ-ийн 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 001/ХТ2020/00777 тогтоол.
14. УДШ-ийн 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 001/ХТ2021/00377 тогтоол.
15. УДШ-ийн 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 001/ХТ2023/00097 тогтоол.

2. Монгол хэл дээрх эх сурвалж

1. Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний эрх зүйн удиртгал, хоёрдугаар дэвтэр*, 2014 он.
2. Батаагийн Тэмүүлэн, Дагвадоржийн Энхзул, Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, 2008 он
3. Бямбажавын Улаанбаатар, *Иргэний эрх зүйн тайлбар толь*, 2005 он.
4. Шихихутаг Их сургууль, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, 2021 он.
5. Содномын Должин, *Хувийн эрх зүйн тайлбар толь бичиг*, УБ, 2019 он.
6. Содовсүрэнгийн Нарангэрэл, *МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН НЭВТЭРХИЙ ТОЛЬ БИЧИГ, хууль зүйн нэр томъёо ба ухагдахуунтай, анхны хэвлэл*, 2021 он.
7. Тэшигийн Мөнхжаргал, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, 1997 он.
8. Түмэнжаргалын Мэндсайхан, *Гэрээний эрх зүй*, 2021 он.
9. Энх-Амгалангийн Байгал, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, 2011 он.
10. Ц.Оюунчимэг, "Иргэний эрх зүйн харилцаа дахь төлөөлөл", *Хууль дээдлэх ёс сэтгүүл*, №1, (2004).

3. Гадаад хэл дээрх эх сурвалж

1. БНСУ-ын Иргэний хууль
2. Ё.Кают нар, *Иргэний хуулийн тайлбар толь, Ерөнхий анги*, 2018 он.
3. Ким Дун Хүн, Ан Гён Хи, Ким Сү Жон, *Иргэний эрх зүйн ойлголт, 3 дугаар хэвлэл*, 2019 он.
4. Күүкмин Их Сургууль, *Солонгосын эрх зүйн удиртгал 1*, 2012 он.
5. Су И На, *Төлөөллийн эрх зүйн ойлголт, онолын тайлбар*, 2008 он.
6. Үсүй Ютака, *Герман улс дахь итгэмжлэл олгосон мэт тооцох хэлцлийн тухай үзэл хандлага Rechtsgeschäftstheorie-ийн сэргэлт*, 2006 он.
7. Hemmer/Wuest, *Zivilrecht I (BGB AT/Vertraegliche Schuldverhaeltnisse) Rn.49*

4 Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>.
2. Хууль зүйн болон бусад салбарын мэдээлэл, судалгаа, шүүхийн шийдвэрийн хайлт, дэлгүүр <https://legaldata.mn>



3. Үсүй Ютака, *Герман улс дахь итгэмжлэл олгосон мэт тооцох хэлцлийн тухай үзэл хандлага Rechtsgeschäftstheorie-ийн сэргэлт*, 2006 он. usui.pdf
4. БНСУ-ын Иргэний хууль, View E-book | Statutes of the Republic of Korea
5. Су И На, Төлөөллийн эрх зүйн ойлголт, онолын тайлбар, 2008 <https://desert.tistory.com/593?fbclid=IwAR3Q5Hq4XimUmJKpc2k7q05xPghZljXSQYIJyxNAkaxafir1jTtNKh0qAH8>
6. "Naver" блог: <https://blog.naver.com/byg416/221984500184>



Article

Apparent authority: a comparative study with the Republic of Korea

ARIUNTES Bayarbold*

Abstract: In civil law relationships, there are cases where a party does not wish, cannot, or is unable to perform the act themselves, and as a result, participates through a representative. However, when a person without full authority to represent another enters into an agreement with a third party, relying on the absence of full authority as the reason to invalidate the contract, it not only fails to protect the trust of the third party but also creates a situation detrimental to them. In this context, the significance of this research lies in anticipating potential disputes arising from apparent authority and providing an analysis of the corresponding legal regulation from a theoretical perspective. This research will also examine how the application of apparent authority is reflected in the judicial practice of Mongolian civil law. Furthermore, the research will explore the enforcement of regulations protecting third parties in cases of unauthorized representation and analyze the theoretical explanation of apparent authority, as well as its incorporation into the law, providing recommendations for improvement. Methodologically, the study will compare the legal regulations of foreign countries. Specifically, the research focuses on the legal systems of Germany and France, as well as South Korea, which has developed a mixed system. The content and terminology of Article 65.1 of the Civil Code of Mongolia closely align with the regulations of South Korea, and the study attempts to incorporate best practices from South Korea into the Mongolian legal framework.

Keywords: Representation, Power of Attorney, Apparent Authority, Party to a Civil Legal Relationship, Third Party

* Lawyer, Attorney.